



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр

Дугаар 6/16

Хэрлэн сум

Г.Пүрэвбаатарыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 34/31 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоолын хавсралт, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Галсанчүлтэмийн Пүрэвбаатарыг Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, гэр бүл, хүүхэд залуучуудын бодлого хариуцсан мэргэжилтнээр 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн шилжүүлэн томилсугай.

2.Ажил хүлээлцэх комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Өнөрцэцэг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Н.Зоригтбаатар Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн


Д.Энхтуяа Архив, бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа Нярав

3.Г.Пүрэвбаатарын цалинг ТЗ-5-1 шатлалаар тогтоон, үндсэн цалинг 642388 (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найман мянган) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

4.Байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Г.Пүрэвбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030156